



НИЙСЛЭЛИЙН  
ӨМЧИЙН ХАРИЛЦААНЫ ГАЗРЫН  
ДАРГЫН ТУШААЛ

2022 оны 01 сарын 31 өдөр

Дугаар А/14

Улаанбаатар хот

Баянгол дүүргийн Дотоод аудитын  
албаны эргэлтийн бус хөрөнгийг данснаас  
хасах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1 дэх хэсэг, 80 дугаар зүйл, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам”-ын 1 дүгээр зүйлийн 1.3 дахь хэсэг, 4 дүгээр зүйлийн 4.6, 4.8 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Эргэлтийн бус хөрөнгийн хөдөлгөөн хариуцсан комисс”-ын 2022 оны 01 дүгээр сарын 27-ны өдрийн хурлын шийдвэрийн дагуу эргэлтийн бус хөрөнгийн дансанд бүртгэлтэй нийт 1,732,688 (нэг сая долоон зуун гучин хоёр мянга зургаан зуун наян найм) төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хавсралтад заасан хөрөнгийг акталж, данс бүртгэлээс хасахыг Баянгол дүүргийн Дотоод аудитын алба (Н.Наранчимэг)-д зөвшөөрсүгэй.

2. Данснаас хасагдаж буй эргэлтийн бус хөрөнгөнөөс 9 нэр төрлийн 1,062,698 (нэг сая жаран хоёр мянга зургаан зуун ерэн найм) төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хөрөнгийг байгууллагын Өмч хамгаалах байнгын зөвлөлийн хяналтан дор устгалын акт үйлдэн зохих журмын дагуу устгаж, 2 нэр төрлийн 669,990 (зургаан зуун жаран есөн мянга есөн зуун ер) төгрөгийн хөрөнгийг хоёрдогч түүхий эдийн зориулалтаар 40,000 (дөчин мянга) төгрөгөөр худалдан борлуулж, орлогын 30 хувь болох 12,000 (арван хоёр мянга) төгрөгийг Нийслэлийн Өмчийн харилцааны газрын төрийн сангийн 1002000510 24 тоот дансанд шилжүүлэхийг Баянгол дүүргийн Дотоод аудитын алба (Н.Наранчимэг)-д, орлого төвлөрүүлэхэд хяналт тавьж ажиллахыг Өмчийн хяналт, ашиглалт, дотоод аудитын хэлтэст тус тус үүрэг болгосугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Орлогч дарга (Б.Болор-Эрдэнэ)-д даалгасугай.



ДАРГА ~~Орлогч дарга~~ М.БАЯРАА

